



**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

**2024 ОНЫ 10 ДУГААР
САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

СӨҮЛ ХОТ

2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАСАГ

I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ:

1. БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн харилцааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.1.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 18 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр цахимаар, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр үйлдвэрийн салбарт ажиллах 11 гэрээт иргэнд ирсний дараах сургалтыг танхимаар зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай
- Солонгос улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Ур чадвартай ажиллах хүч E-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал гэх мэт.

Түүнчлэн үйлчилгээний салбарт ажиллахаар ирсэн 6 гэрээт иргэнтэй Ичон хотод уулзалт хийж зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

1.1.2 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2024 оны 10 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **193** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэргээр үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажилласан.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын газраас оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах зардлын даатгалын мөнгө, Хөдөлмөр, халамжийн корпорацаас үйлдвэрлэлийн ослын даатгалын нөхөн олговор, ажил олгогчдоос үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс зэрэг хэлбэрээр нийт **163,202,515.00** воныг Монгол Улсын 14 иргэнд олгуулсан.

Хүснэгт 1: Ажил үйлчилгээний төрлөөр иргэдэд олгуулсан мөнгөн дүнгийн жагсаалт

Ажил үйлчилгээний төрөл		Мөнгөн дүн /вон/
Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	Буцах замын зардал	2,500,000.00
	Самсунг даатгал дахь 13 дахь сарын цалин	22,867,300.00
	Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалин	886,415.00
	Үйлдвэрлэлийн ослын даатгалын нөхөн олговор	128,000,000.00
Бусад төрлийн визтэй иргэдэд	Олгогдоогүй, хойшлогдсон цалин хөлс	1,900,000.00
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13 дахь сарын цалин	7,048,800.00

НИЙТ ОЛГУУЛСАН ДҮН	163,202,515.00
--------------------	----------------

Тухайлбал: Хөдөлмөрийн гэрээт ажилчин Б.3 нь нас барсан тул нас барсны нөхөн олговрыг олгуулахаар холбогдох баримтыг бүрдүүлэн, өргөдөл гаргасан ба нас барсан шалтгааныг гэнэтийн осол бус үйлдвэрлэлийн осол гэж үзээд Хөдөлмөр халамжийн корпорацаас нөхөн олговорт 128,000,000 вон олгосон.

1.1.1 Төрийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор БНСУ-ын Өмнөд Гёнсан аймгийн Чангвон хотод 2024 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан “Олон улс үндэстний соёл урлагийн наадам”-д оролцож, БНСУ-ын болон Монгол Улсын төрийн, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллав. Арга хэмжээний үеэр явуулын үйлчилгээг зохион байгуулж иргэдэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны гарын авлага 60 ширхгийг тарааж, 10 иргэнд хөдөлмөрийн харилцаатай холбоотой бусад зөвлөгөө, мэдээлэл өгч мөн 38 иргэнд нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийг сурталчлан таниулж, сурталчилгааны материал тарааж ажилласан.

1.1.2 Төвийн даргын 2024 оны 10 дугаар сарын 04-ний А/05 дугаар тушаалаар “Монгол гэр бүл өдөрлөг”-ийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг байгуулсны дагуу, ерөнхий болон нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан, ажлын хэсгийг 3 удаа хуралдуулж зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэв. Хилийн чанадад оршин суугаа Монгол Улсын үнэт зүйл болсон гэр бүл, хүүхэд залуус, иргэдийнхээ дуу хоолойг сонсох, хэрэгцээ шаардлагад нийцсэн нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх зорилготой тус өдөрлөгийг БНСУ-ын Сөүл хотноо 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан ба Монгол Улсын яам, агентлагийн төлөөлөгч, албан хаагчид, БНСУ-д үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, нэгдлүүдийн төлөөлөл, Солонгос Улсын төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид, Монгол улсын иргэд, хүүхэд багачууд нийт 270 хүн оролцсон.

2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр тогтвор суурьшилтай ажиллан ур чадвартай ажиллах хүчний визний ангилал руу шилжүүлэх ажлын хүрээнд:

1.2.1 Е-7-4 визний асуудлаар нийт 7 иргэнтэй утас болон цахимаар холбогдож оноо цуглуулах, гэр бүлийн гишүүдийг урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, визний ангиллаа дараагийн ангилал руу өөрчлөх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, бүртгэлийн санг баяжуулсан.

3. БНСУ-д оршин сууж байгаа Монгол иргэдэд гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж, дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд:

1.3.1 Монголоос ирсэн салбарын төлөөлөгчид оролцсон албан уулзалтыг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Сөүл хотын бүс нутаг хариуцсан төвтэй зохион байгуулж, гэр бүлийн бодлого, үйл ажиллагаатай танилцуулан, туршлага судлах ажлыг хэрэгжүүлсэн.

1.3.2 БНСУ-д оршин суугаа Монгол Улсын иргэдэд сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх чиглэлээр, ганцаарчилсан сэтгэл засал нийт 12 хүнд, үүнээс нойргүйдэл, сэтгэл гутрал болон сэтгэл түгшилт илрүүлэх сорилыг 10 хүнд, бусад сорил 2 удаа тус тус хийлгэж, дүгнэлт хийсэн.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСАГ

2. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд хамруулах ажлын хүрээнд:

2.1.1 Тайлант хугацаанд нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд 23 иргэнийг шинээр хамруулан “Солонгос Улсад гэрээгээр ажиллагсдын программ”-д мэдээллийг бүртгэн гэрээ байгуулсан. Мөн нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд шинээр 22, гэрээний хугацаа сунгасан 25, ажлын байраа сольсон, гэрчилгээг гэж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 5, нийт 52 даатгуулагчид Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг тус тус бичиж олгосон.

2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн визний ангиллаар оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах ажлын хүрээнд:

2.2.1 Нийт 44 иргэнийг сайн дурын нийгмийн даатгалд шинээр хамруулж, БНСУ-ын ААН-д хөдөлмөр эрхэлдэг 61 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгосон.

3. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, тайлагнах ажлын хүрээнд:

2.3.1 НДЕГ-ын даргын 2024 оны А/02 дугаар тушаалаар тус тасгийн 2024 оны орлогын батлагдсан төлөвлөгөө 4,997,799,000.00 төгрөг, сар бүрийн орлогын төлөвлөгөө 416,483,250.00 төгрөг болно. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 59 хувиар биелүүлсэн бөгөөд хүснэгт 2-оор харуулбал:

Хүснэгт 2: Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого	Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний даваа гарагийн хаалтын ханш
		Вон	Төгрөг		Вон	Төгрөг		
10	416,483,250.00	40,099,850.00	101,051,622.00	146,455,768.00	40,099,850.00	247,507,390.00	59	2.52

2.3.2 Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын ажил олгогчдод тухайн сарын болон өмнөх саруудын 563 ширхэг шимтгэл төлөх нэхэмжлэл факсаар илгээн, нийт 730 даатгуулагчтай шимтгэл төлөхийг сануулж, утсаар холбогдсон.

2.3.3 Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн 10 дугаар сарын шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн сан дахь холбогдох дансанд шилжүүлэн, тайлан мэдээг гарган тус газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

4. Тэтгэмж авах эрх үүссэн даатгуулагчдад баримт олгох ажлын хүрээнд:

2.4.1 Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн 4 даатгуулагчид шаардлагатай бичиг баримтыг Монгол хэлнээ хөрвүүлж, зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж өгсөн.

5. Иргэд, даатгуулагчид болон ажил олгогчдод нийгмийн даатгалын талаар мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх, тэдний хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд:

2.5.1 Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 417, үүнээс 365 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 52 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын

хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажилласан. Мөн БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд ирсний дараах сургалтыг 10 дугаар сарын 24-ний өдөр танхимаар зохион байгуулж 11 гэрээт иргэн болон Ичон сургалтын төв дээр үйлчилгээний салбарт ажиллахаар ирсэн хөдөлмөрийн гэрээт 7 иргэнийг тус тус хамруулан Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийн тухай сургалтыг зохион байгуулж, сурталчилгааны материал тарааж ажилласан.

6. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанаас шимтгэлийн буцаан олголтыг олгуулах ажлын хүрээнд:

2.6.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар хүсэлт ирүүлж УТА-д илгээсэн 209, 210 дугаар ээлжийн 5 иргэний хүсэлтийг шийдвэрлүүлэхээр БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлсэн.

3.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

1. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сахилга хариуцлагыг чангатгах, ажлын бүтээмж, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн ажлын хүрээнд:

3.1.1 Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй “7:4:10” сургалтын 2 удаагийн хөтөлбөрт төвийн нийт албан хаагчид хамрагдсан.

Мөн 10 дугаар сарын 25-ны өдөр НДЕГ-аас зохион байгуулсан “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн анхаарах асуудлууд” сэдэвт сургалтад нийгмийн даатгалын тасгийн мэргэжилтнүүд хамрагдсан.

3.1.2 Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 38 удаа, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 15 удаагийн мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар 51,020 орчим хандалт авсан.

3.1.3 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдөр БНСУ-д үйл ажиллагаагаа явуулж буй 15 төрийн бус байгууллага, Сөүл хотын олон соёлын төвийн Гадаад иргэдийн хэлтэс, Гёнги аймгийн хойд бүсийн Монголын Улсын өргөмжит консул, Сөүл хотын гэр бүлийн төв, Сөүлийн гадаад иргэдийг дэмжих төв, “Сөүл Глобал” өсвөр насны залуучуудын боловсролын төв, Гандун дүүргийн гадаад иргэдийг дэмжих төв, Сөүлийн цагдаагийн газар, Солонгос дахь Монгол сургууль, Гэр бүл, сэтгэл зүйн “Намү” төв зэрэг байгууллагатай хамтран ажиллаж, “Монгол гэр бүл” нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж ажилласан.

Сөүл хотын Өмнөд хэсгийг хариуцсан бүс нутгийн хөдөлмөр, халамжийн төвтэй туршлага солилцох албан уулзалтыг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон бусад төлөөлөгчид оролцсон.

Солонгосын Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн үйлчилгээний төвтэй Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөлөлтэй туршлага солилцох уулзалтыг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан.

Хүүхэд гэр бүл, хүүхэд хамгааллын газрын дарга болон албаны бусад хүмүүсийн хамт 2024 оны 10 сарын 24-ний өдөр Намъянжү хотын Монгол соёлын төвийн нээлтэд оролцсон.

3.1.4 “Цалин хөлсний маргааныг шийдвэрлэх үе шат”-ны танилцуулгыг орчуулан бэлтгэсэн.

3.1.5 Гадаад иргэний хөдөлмөр эрхлэлтэд хамааралтай нэн тэргүүнд орчуулах шаардлагатай хуулийн жагсаалтыг гарган Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн ажилтнууд хуваарийн дагуу орчуулж байна.

3.1.6 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн албан хаагчдын бэлтгэсэн гарын авлагаар мэдлэг хуваалцах сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулсан.

3.1.7 Төвийн танилцуулга болон хүүхэд гэр бүлийн статистик мэдээллийг шинэчлэн боловсруулсан.

3.1.8 БНСУ-д оршин сууж буй Монгол иргэдийн тоон мэдээллийг шинэчлэн бэлтгэсэн.

3.1.9 БНСУ-д гэрээт ажилтан илгээх болон БНСУ-д ирсний дараах процессын дагуу танилцуулга бэлтгэсэн.

3.1.10 Нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх 20 иргэний хүсэлтийг хүлээн авч, бүртгэлийг баталгаажуулан, иргэдэд бүртгүүлэх кодыг холбогдох программаас илгээсэн. Мөн нийгмийн даатгалын лавлагаа авах хүсэлт гаргасан 7 иргэний хүсэлтийн дагуу мэдээллийг холбогдох программаас шүүж, хүлээлгэн өгсөн.